



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/159/СТА-ТШЗ

Цахим хуудас:
bayankhongor@audit.gov.mn
Баянхонгор хот
2020 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цээням

Утас: 70442424 Цахим хаяг: tseehyama@audit.gov.mn

Аудитор: Д.Цэцэгмаа

Утас: Цахим хаяг:

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	9
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.13. Шилэн дансны мэдээлэл	10
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	10
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
Менежментийн захидал.....	11
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	13
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	18
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	20



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584

E-mail: bayankhongor@audit.gov.mn

2020.02.11 № 1/65

танай _____ -ны № _____ -т

Г Аудитын гэрчилгээ Г

БАЯНХОНГОР АЙМГИЙН
СТАНДАРТ, ХЭМЖИЛЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА М.ХОСБАЯР
ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\
005020022

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

Аудитын тайлан

2.1. Оршил

Баянхонгор аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг хэлтсийн дарга М.Хосбаяр Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 31-нээс 2020 оны 02 дугаар сарын 3-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 05 -ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт аудитор Д.Цэцэгмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 06 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Эрхэм зорилго:

Бараа бүтээгдэхүүн ажил үйлчилгээний, чанар стандарт, хэмжилзүй, сорьцын баталгаат байдлыг хууль тогтоомжийн хүрээнд хангуулж, аймаг орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулахад оршино.

Чиг үүрэг:

- ❖ Бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалт
- ❖ Хэмжүүр, хэмжих хэрэгслийн баталгаажуулалт
- ❖ Стандарт салбар сангийн түгээлт
- ❖ Үнэт металл сорьц тогтоох хяналт

Тайлант хугацаанд дараах зорилтуудыг дэвшүүлсэн байна. Үүнд:

- Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль бусад холбогдох хууль тогтоомж, журмыг хэрэгжүүлэн ажилладаг бөгөөд итгэмжлэлийн хүрээний тодорхойлолтод заасны дагуу байгууллага, аж ахуй нэгж, үйлдвэр, худалдаа, үйлчилгээний газруудад ашиглагдаж байгаа цахилгаан, эзэлхүүн, даралт, массын хэмжлийн төрлөөр хэмжүүр, хэмжих хэрэгслүүдэд анхдагч болон ээлжит давтан баталгаажуулалтын ажлыг чанартай хийж гүйцэтгэх

- Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 291 дугаар тогтоолоор батлагдсан “Тохирлын баталгаанд заавал хамрагдах бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалт”-д багтсан бүтээгдэхүүн, үйлчилгээг баталгаажуулж “Тохирлын гэрчилгээ” олгоно.

- Стандарт болон техникийн зохицуулалт, дүрэм журам, норматив техникийн баримт бичиг, тэдгээртэй хобоотой мэдээллийг олон нийтэд хүргэх, мэдээлэх, сурталчилах, үндэсний болон Олон улс, бүс нутгийн стандартаар танхимаар болон цахим хэлбэрээр иргэн, аж ахуй нэгж байгууллагад түргэн шуурхай үйлчилгээ үзүүлэх

- Монгол Улсын нутаг дэвсгэрт үнэт металл, эрдэнийн чулуу олборлолт, боловсруулалт, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулдаг бүхий л байгууллага, иргэдийн үнэт металл, эрдэнийн чулуу, тэдгээрээр хийсэн эдлэлийн сорьц тогтоох, шинжилгээ хийж, баталгаажуулах, эрдэнийн чулууг таньж тодорхойлон гэрчилгээ олгох, алт хайлж гулдмайлах ажил үйлчилгээ эрхлэхийн зэрэгцээ үнэт металл, эрдэнийн чулуугаар үйлдвэрлэл үйлчилгээ явуулж байгаа аж ахуй нэгж, байгууллага, иргэдийн сорьцын баталгаажуулалтын байдалд хяналт тавьж, холбогдох хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, түүнчлэн лабораториудын багаж, тоног төхөөрөмжийн хүчин чадал, техник технологи, аргачлалыг байнга сайжруулах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Баянхонгор аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Acolous программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Баянхонгор аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 31 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны 3 дугаар улирлын байдлаарх санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “их” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2,0 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн шатанд төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 263053,2 мянган төгрөгөөс тооцон 5261,1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 5261,1 мянган төгрөгөөр тооцсон нь төлөвлөлтийн шатанд суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн зардлыг сонгосонтой холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 13471,5 мянган төгрөгөөр буюу 7,6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн дансад байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0,00	0,00	0,00
Авлага	2737,6	2711,8	-25,8
Урьдчилгаа	0,00	0,00	0,00
Бараа материал	7446,1	13713,7	6267,6
Үндсэн хөрөнгө	166191,2	173420,9	7229,7
Нийт хөрөнгө	176374,9	189746,4	13371,5
Өр төлбөр	0,00	24,9	24,9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	176374,9	189821,5	13446,6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	176374,9	189846,4	13471,5

Авлага дансны үлдэгдэл нь нэмэлт санхүүжилтийн данснаас төсөвт татан төвлөрүүлсэн дүнг системийн дээд байгууллагын шийдвэрээр авлагаар тусгасан бөгөөд

өмнөх оноос буурсан нь тайлант хугацаанд төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүн өмнөх онохоос бага байснаас шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь тайлант хугацаанд сорьцын лаборатори ашиглалтад орсонтой холбоотой оны эхэнд эм, боох материалын 3070,4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан бол эмнэлгийн багаж хэрэгсэл, урвалж бодис зэргийг өөрийн орлогын эх үүсвэрээс 11553,1 мянган төгрөгөөр худалдан авч, бусад байгууллагаас үнэ төлбөргүй 787,3 мянган төгрөгийн, нийт 12340,4 мянган төгрөгөөр нэмэгдэж 9321,1 мянган төгрөгийн зарцуулалт хийгдэж оны эцэст 6089,7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь тайлант хугацаанд нийт 13110,9 мянган төгрөгөөр хөрөнгө худалдан авсны дотор өөрийн орлогын төлөвлөгөөнөөс давсан эх үүсвэрээс 12695,9 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө худалдан авсан нь нөлөөлжээ.

Биет бус хөрөнгөнд өөрчлөлт ороогүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 24,9 мянган төгрөгөөр өссөн нь шатахууны өглөг үүссэнээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 189821,5 мянган төгрөг болж 13446,6 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авсан үндсэн хөрөнгийн хэмжээгээр тайлант үеийн үр дүнд нөлөөлснөөс шалтгаалжээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга гараагүй байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Баянхонгор аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтэс нь тайлант онд 55000,0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 64078,3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 116,5 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1.Хэмжүүр баталгаажуулалтын орлого		46715,7		
2.Стандарт борлуулалтын орлого		1867,6		
3.Үнэт металлын сорьцын орлого		14534,3		
Нийт дүн	55000,0	64078,3	9078,3	116,5

Үндсэн үйл ажиллагаанаас төвлөрүүлэх орлого 9078,3 мянган төгрөгөөр давсан байна.

Орлогын төлөвлөгөөг дээд шатны байгууллагаас нэр төрлөөр нь задалж өгөөгүй тул орлогын нэр төрлөөр төлөвлөгөөний биелэлтэд дүгнэлт өгөх боломжгүй байна.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 180194,0 мянган төгрөгийн төсөв батлагдсаныг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 180194,0 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Зардлыг санхүүжүүлсэн орлогын гүйцэтгэлийг судалж үзэхэд Төсвийн тухай хуулиар батлагдсаны дагуу санхүүжилтийг улсын төсвөөс олгосон байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулан үзэхэд батлагдсан хэмжээндээ зарцуулалт хийгджээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 180193,5 мянган төгрөг буюу 100,0 хувьтай байгаа нь олгосон санхүүжилтийг бүрэн зарцуулсан байна..

Нэмэлт төсөв: Тайлант хугацаанд дээд шатны төсвийн захирагчаас өмнөх оны нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдлийг төвлөрүүлснийг авлагаар бүртгэснийг буцаан олгосон 2709,5 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 29627,6 мянга, нийт 32332,7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс үндсэн хөрөнгө худалдан авахад 12695,9 мянган, бусад урсгал зардалд 16935,9 мянган, нийт 29631,8 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 2700,9 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж авлагаар бүртгэсэн байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 31 эрсдэл тодорхойлж, гүйцэтгэх үе шатанд нэмж эрсдэл сонгоогүй, нийт 7 чиглэлд 31 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 31372,3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 4445,6 мянган төгрөгийн алдааг залруулж, 26926,7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Аудитаар төлбөрийн акт тогтоох албан шаардлага хүргүүлэх залруулагдаагүй алдаа, зөрчил илрээгүй байна.

Аудитаар илэрсэн 26926,7 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Монгол улсын Засгийн газрын 2018 оны 275 тоот тогтоолоор орон нутагт үнэт металлын сорьц тогтоох чиг үүрэг бүхий лабораторийг аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн бүтцэд байгуулсан байна. Тайлант хугацаанд үнэт метал сорьцын хяналт, баталгаажуулалтаас төсвийн жилийн дундуур нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн орлого 29627,7 мянган төгрөгөөс 26926,7 мянган төгрөгийг зарцуулах хүсэлтийг аймгийн Стандарт хэмжилзүйн хэлтсээс 2019 оны 7-р сар, 9-р саруудад Стандарт, хэмжил зүйн газарт 2 удаа хүргүүлсэн байна. Стандарт хэмжилзүйн газрын эрх бүхий албан тушаалтнууд дээрхи хүсэлтийг Сангийн яамнаас шийдвэр гараагүй байхад 2019 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр нэмэлт орлогын зарцуулалтын эрхийн хүсэлтийг баталж өгснөөр хэлтсийн даргын 2019 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн А/33 тоот тушаалаар зарцуулсан нь Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ыг зөрчсөн байна.

Дээрх зөрчил нь орон нутгийн байгууллагаас хамааралгүй тул санал дүгнэлтэд нөлөөлүүлээгүй бөгөөд Стандарт, хэмжилзүйн газрын ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар авч үзэх шаардлагатай.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар 2019 оны мэдээлэл оруулсан байдал дараах байдалтай байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	7	2	2
2	Хагас жил	4	4	4		
3	Улирал бүр	1	4	4		
4	Сар бүр	3	36	32	4	
	Тухай бүр	8	96	89	7	
	Нийт	27	151	136	13	2

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд итгэл үзүүлж аудит хийгдээгүй учир зөвлөмж өгөгдөөгүй байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор аймгийн Стандарт хэмжилзүйн хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Баянхонгор аймгийн Стандарт хэмжилзүйн хэлтсийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Орлого данстай данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд үндсэн бус үйл ажиллагаанаас төсвийн жилийн дундуур төвлөрсөн орлого 29627,7 мянган төгрөгөөс 26926,7 мянган төгрөгийг СХЗГ-аас өгсөн чиглэлийн дагуу хэлтсийн даргын 2019 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн А/33 тоот тушаалаар зарцуулсан нь Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ыг зөрчсөн байна.

1.2. Эрсдэл:

Улсын төсөвт төвлөрөх орлогыг дутуу төвлөрүүлэх, батлагдсан төсөв хэтрэх, төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах

1.3. Өгсөн зөвлөмж:

1. Төсвийг төлөвлөхдөө үндсэн үйл ажиллагаанаас төвлөрүүлэх орлогыг бодитой төлөвлөх

2. Төсвийн жилийн дундуур шинээр бий болсон орлогыг зарцуулахдаа Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ыг мөрдөж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>10,183,719.35</u>	<u>16,425,545.70</u>
33	АВЛАГА	2,737,641.06	2,711,798.55
335	Бусад авлага	2,737,641.06	2,711,798.55
3351	Байгууллагаас авах авлага	2,737,641.06	2,711,798.55
35	БАРАА МАТЕРИАЛ	7,446,078.29	13,713,747.15
351	Түүхий эд материал	3,118,217.00	6,136,751.00
35110	Тусгай зориулалттай материал	47,780.00	47,000.00
35130	Эм боох материал	3,070,437.00	6,089,751.00
354	Хангамжийн материал	4,327,861.29	7,576,996.15
35410	Бичиг хэргийн материал	1,012,650.00	1,266,500.00
35420	Аж ахуйн материал	3,315,187.70	6,310,495.73
35440	Түлш, шатах тослох материал	23.59	00.42
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>166,191,240.25</u>	<u>173,404,384.27</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	166,191,240.25	173,404,384.27
392	Биет хөрөнгө	130,421,240.25	137,700,384.27
39201	Барилга, байгууламж, орон сууц	127,029,515.90	127,029,515.90
39202	Хуримтлагдсан элэгдэл	-3,114,687.90	-6,762,897.30
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	22,800,504.20	29,484,404.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	-20,443,837.45	-21,785,771.59
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,258,181.22	14,185,241.22
39208	Хуримтлагдсан элэгдэл	-7,108,435.72	-7,950,108.16
39209	Зам, гүүрийн байгууламж	00.00	3,500,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,810,000.00	4,810,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-4,810,000.00	-4,810,000.00
393	Биет бус хөрөнгө	35,770,000.00	35,704,000.00
39301	Програм хангамж	896,000.00	896,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-676,000.00	-742,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	35,550,000.00	35,550,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>176,374,959.60</u>	<u>189,829,929.97</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>24,920.46</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	24,920.46
413	Өглөг	00.00	24,920.46

Баянхонгор аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	24,920.46
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	176,374,959.60	189,805,009.51
51	Засгийн газрын хувь оролцоо	176,374,959.60	189,805,009.51
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	96,568,996.01	96,568,996.01
51101	Өмч: - төрийн	96,568,996.01	96,568,996.01
512	Хуримтлагдсан үр дүн	22,707,877.60	36,137,927.51
51210	Өмнөх үеийн үр дүн	22,707,877.60	22,707,877.60
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	13,430,049.91
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	57,098,085.99	57,098,085.99
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	176,374,959.60	189,829,929.97

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	238,158,890.50	279,129,133.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	91,508,970.50	96,225,773.00
120	Нийтлэг татварын бус орлого	56,783,770.50	96,225,773.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	49,617,897.50	93,625,773.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	46,777,519.00	64,078,257.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,056,455.00	27,427,660.00
1200046	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих/ хүүгийн орлого/	91,630.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,692,293.50	2,119,856.00
120005	Түрээсийн орлого	00.00	2,200,000.00
120009	Бусад орлого	7,165,873.00	400,000.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	34,725,200.00	00.00
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	34,725,200.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	146,649,920.00	182,903,360.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	144,549,500.00	180,193,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	144,549,500.00	180,193,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	2,709,560.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	2,709,560.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	2,100,420.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	2,100,420.00	00.00

Баянхонгор аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	199,297,215.77	265,699,083.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	199,297,215.77	265,699,083.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	140,569,454.22	200,720,538.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	90,809,083.68	129,243,066.00
210101	Үндсэн цалин	90,809,083.68	129,243,066.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,894,274.20	16,346,512.66
210201	Тэтгэврийн даатгал	7,316,733.20	11,187,115.92
210202	Тэтгэмжийн даатгал	1,010,289.00	1,366,706.74
210203	ҮОМШӨ-ний даатгал	716,071.00	1,018,154.00
210204	Ажилгүйдлийн даатгал	168,290.00	252,231.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,682,891.00	2,522,305.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,367,939.50	16,066,766.90
210301	Гэрэл, цахилгаан	907,905.00	6,586,706.90
210302	Түлш, халаалт	7,333,560.00	6,554,240.00
210303	Цэвэр, бохир ус	1,126,474.50	2,925,820.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,167,641.71	10,778,265.10
210401	Бичиг хэрэг	2,345,140.00	3,321,210.00
210402	Тээвэр, шатахуун	2,888,704.41	3,658,832.63
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	443,041.50	798,649.77
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,490,755.80	2,999,572.70
2105	Нормативт зардал	2,666,418.00	9,526,142.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,666,418.00	9,326,142.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	200,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,202,500.00	262,100.00
210604	Урсгал засвар	6,202,500.00	262,100.00
2107	Томилолт, зочны зардал	5,166,200.00	6,549,750.00
210702	Дотоод албан томилолт	5,166,200.00	6,549,750.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	307,950.00	4,513,120.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	147,000.00	4,071,660.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	150,000.00	160,000.00
210807	Газрын төлбөр	10,950.00	11,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	00.00	270,460.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,987,447.13	7,434,815.98
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	392,000.00	1,537,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,248,349.95	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	5,347,097.18	5,897,815.98
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58,727,761.55	64,978,544.45
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,086,320.00	499,950.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	2,100,420.00	00.00

Баянхонгор аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4,985,900.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	499,950.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	51,641,441.55	64,478,594.45
213306	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	64,478,257.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	51,641,441.55	337.45
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>38,861,674.73</u>	<u>13,430,049.91</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	65,000.00	00.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	65,000.00	00.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	43,472,090.93	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	191,283.60	00.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	65,000.00	00.00
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	43,215,807.33	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-43,407,090.93	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-4,545,416.20</u>	<u>13,430,049.91</u>

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>201,317,267.00</u>	<u>277,009,277.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<u>54,667,347.00</u>	<u>94,105,917.00</u>
120	Нийтлэг татварын бус орлого	54,667,347.00	94,105,917.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	47,833,974.00	91,505,917.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	46,777,519.00	64,078,257.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,056,455.00	27,427,660.00
120005	Түрээсийн орлого	00.00	2,200,000.00
120009	Бусад орлого	6,833,373.00	400,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>146,649,920.00</u>	<u>182,903,360.00</u>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	144,549,500.00	180,193,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	144,549,500.00	180,193,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	2,709,560.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	2,709,560.00

Баянхонгор аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	2,100,420.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	2,100,420.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	199,917,266.99	263,898,317.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	199,917,266.99	263,898,317.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	141,189,505.44	196,218,797.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	90,952,119.54	129,397,558.93
210101	Үндсэн цалин	57,933,819.54	88,248,958.93
210102	Нэмэгдэл	19,518,800.00	35,449,300.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,953,100.00	5,699,300.00
210105	Гэрээт ажлын хөлс	9,546,400.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,913,998.31	16,174,762.12
210201	Тэтгэврийн даатгал	8,339,424.47	10,999,062.12
210202	Тэтгэмжийн даатгал	852,500.00	1,186,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	681,900.00	1,056,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	170,500.00	345,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	869,673.84	2,588,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,790,745.00	13,790,730.00
210301	Гэрэл, цахилгаан	1,288,005.00	4,310,670.00
210302	Түлш, халаалт	7,244,160.00	7,589,120.00
210303	Цэвэр, бохир ус	3,258,580.00	1,890,940.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,904,817.59	4,602,101.50
210401	Бичиг хэрэг	1,462,858.00	999,560.00
210402	Тээвэр, шатахуун	3,691,073.59	2,027,469.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	480,436.00	898,399.77
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,270,450.00	676,672.73
2105	Нормативт зардал	5,747,955.00	7,725,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,747,955.00	7,725,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,420,500.00	1,851,040.00
210602	Тавилга	00.00	302,940.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	420,000.00
210604	Урсгал засвар	4,420,500.00	1,128,100.00
2107	Томилолт, зочны зардал	5,949,700.00	3,666,700.00
210702	Дотоод албан томилолт	5,949,700.00	3,666,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,967,850.00	16,660,904.90
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,733,900.00	15,844,744.90
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	150,000.00	160,000.00
210807	Газрын төлбөр	10,950.00	11,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	73,000.00	645,160.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,541,820.00	2,350,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	792,000.00	2,300,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,749,820.00	50,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58,727,761.55	67,679,519.55

Баянхонгор аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2132	Бусад урсгал шилжүүлэг	7,086,320.00	499,950.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	2,100,420.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4,985,900.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	499,950.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	51,641,441.55	67,179,569.55
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	64,478,257.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	51,641,441.55	2,701,312.55
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1,400,000.01	13,110,960.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,400,000.00	13,110,960.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,400,000.00	13,110,960.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,400,000.00	13,110,960.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,400,000.00	13,110,960.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-1,400,000.00	-13,110,960.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.01	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.01	00.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	61,018,996.02	1,884,947.90	25,391,375.65	00.00	88,295,319.57
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-620,897.00	00.00	-620,897.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	61,018,996.02	1,884,947.90	24,770,478.65	00.00	87,674,422.57
C07	Тайлант үеийн үр дүн	35,550,000.00	00.00	-4,545,416.20	00.00	31,004,583.80
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	96,568,996.01	57,098,085.99	22,707,877.60	00.00	176,374,959.60

Баянхонгор аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит						
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	96,568,996.01	57,098,085.99	22,707,877.60	00.00	176,374,959.60
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	96,568,996.01	57,098,085.99	22,707,877.60	00.00	176,374,959.60
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	13,430,049.91	00.00	13,430,049.91
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	96,568,996.01	57,098,085.99	36,137,927.51	00.00	189,805,009.51

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	128,571,400.00	118,540,575.08	180,193,800.00	180,193,462.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	128,571,400.00	118,540,575.08	180,193,800.00	180,193,462.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	116,194,400.00	115,359,579.08	179,693,800.00	179,693,512.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	91,506,800.00	91,466,896.00	129,397,600.00	129,397,558.93
210101	Үндсэн цалин	75,388,800.00	76,449,107.00	88,249,000.00	88,248,958.93
210102	Нэмэгдэл	00.00	00.00	36,990,600.00	35,449,300.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,993,000.00	4,690,620.00	4,158,000.00	5,699,300.00
210105	Гэрээт ажлын хөлс	12,125,000.00	10,327,169.00	00.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,418,600.00	10,061,357.48	16,174,800.00	16,174,762.12
210201	Тэтгэврийн даатгал	6,405,600.00	10,061,357.48	10,998,800.00	10,999,062.12
210202	Тэтгэмжийн даатгал	732,000.00	00.00	1,294,000.00	1,186,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	915,000.00	00.00	1,035,200.00	1,056,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	183,000.00	00.00	258,800.00	345,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	183,000.00	00.00	2,588,000.00	2,588,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,828,400.00	8,829,070.00	13,790,800.00	13,790,730.00
210301	Гэрэл, цахилгаан	754,500.00	599,898.00	1,909,700.00	4,310,670.00

Баянхонгор аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210302	Түлш, халаалт	8,065,900.00	7,747,592.00	8,683,200.00	7,589,120.00
210303	Цэвэр, бохир ус	1,008,000.00	481,580.00	3,197,900.00	1,890,940.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,415,400.00	2,309,599.60	4,597,700.00	4,597,601.50
210401	Бичиг хэрэг	268,800.00	157,920.00	790,000.00	995,060.00
210402	Тээвэр, шатахуун	1,841,400.00	1,612,154.60	2,027,700.00	2,027,469.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	305,200.00	539,525.00	780,000.00	898,399.77
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	00.00	200,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	00.00	800,000.00	676,672.73
2105	Нормативт зардал	170,000.00	66,000.00	8,000,000.00	8,000,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	150,000.00	00.00	8,000,000.00	8,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	20,000.00	66,000.00	00.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	104,000.00	68,000.00	2,000,000.00	2,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	36,000.00	00.00	00.00	00.00
210602	Тавилга	00.00	00.00	00.00	451,900.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	00.00	1,000,000.00	420,000.00
210604	Урсгал засвар	68,000.00	68,000.00	1,000,000.00	1,128,100.00
2107	Томилолт, зочны зардал	2,838,200.00	2,046,000.00	3,666,700.00	3,666,700.00
210702	Дотоод албан томилолт	2,838,200.00	2,046,000.00	3,666,700.00	3,666,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	863,000.00	512,656.00	816,200.00	816,160.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	390,000.00	330,800.00	00.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.00	160,000.00	160,000.00	160,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	95,000.00	00.00	00.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	53,000.00	00.00	00.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	15,000.00	00.00	00.00	00.00
210807	Газрын төлбөр	00.00	21,856.00	11,000.00	11,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	150,000.00	00.00	645,200.00	645,160.00

Баянхонгор аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50000.00	0.00	1250000.00	1250000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	00.00	1,200,000.00	1,200,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	50,000.00	00.00	50,000.00	50,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12377000.00	3180996.00	500000.00	499950.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,377,000.00	3,180,996.00	500,000.00	499,950.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,213,000.00	3,180,996.00	00.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	164,000.00	00.00	500,000.00	499,950.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	145,218,400.00	133,540,575.49	180,193,800.00	180,193,462.55
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	130,218,400.00	118,540,575.49	180,193,800.00	180,193,462.55
131001	Улсын төсвөөс санхүүжих	130,218,400.00	118,540,575.49	180,193,800.00	180,193,462.55
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	15,000,000.00	15,000,000.00	00.00	00.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,000,000.00	15,000,000.00	00.00	00.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01	01	01	01
610001	Төсвийн байгууллага	01	01	01	01
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	10	10	13	13
620001	Удирдах ажилтан	01	01	01	01
620002	Гүйцэтгэх ажилтан	06	06	09	09
620003	Үйлчлэх ажилтан	01	01	01	01
620004	Гэрээт ажилтан	02	02	02	02
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	10	10	13	13
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	04	04	04	04
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	05	05	08	08
650010	Гэрээт ажилтан	01	01	01	01

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

НТ-2

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2790355.00	29,631,744.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2790355.00	29,631,744.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2790355.00	29,631,744.90
2104	Хангамж, бараа материалын зардал	218500.00	00.00
210401	Бичиг хэрэг	48000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	170500.00	00.00
2105	Нормативт зардал	737955.00	00.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	737955.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1733900.00	28,531,744.90
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1733900.00	28,531,744.90
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	100000.00	1100000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		1,100,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	100000.00	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

АУДИТЫН ТАЙЛАНГ:

БЭЛТГЭСЭН: ГЭРЭЭТ АУДИТОР *[Signature]* Д.ЦЭЦЭГМАА

АНХАН ШАТАНД ХЯНАСАН: АУДИТЫН МЕНЕЖЕР

ХОЁРДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

[Signature] А.ЦЭЭНЯМ

[Signature] Б.МӨНХБАТ

Огноо: 2020.02.10

